

“Булан”, Лин Тэнсей

“Өнөөдөр маш сайхан өдөр байна” хэмээн өнөө шөнө хэрэгтэй хувцасаа бэлдэх зуураа би бодлоо. Тиймээ, өнгөрсөн цөөн хэдэн жилүүдэд гаргаж чадсан амжилтандaa би сэтгэл хангалуун байна. Би өөрөө өөртөө сэтгэл хангалуун бөгөөд инээж, өөрт оногдсон даалгавараа хийхдээ баяртай байсан. Миний ажил амжилтын оргилд хүрэх цаг надад ойрхон мэт санагдсан. Миний итгэж байсан зүйл бүхэн биелэх гэж байна.

Би өөрийн том савхин цүнх доторх биеэ хамгаалах бүх хэрэгсэл болох бэлгэвч, тос /лубрикант/ болон тэмдэглэлийн дэвтрээр дүүрэн байхыг харлаа. Төслийн ажилтаны хувьд, ажилаа эхэлж байх үед миний эгч дүүс мэт байсан Плимот хотын биеэ үнэлэгч / эмэгтэйчүүдийн төлөө ямар нэгэн зүйл хийж байгаагаа мэдэрч байлаа.

Энэ нь олон жилийн өмнөөс шаардлагатай байсан гэдгийг би санаж байна. Би олон төрлийн байгууллагад сайн дураар ажиллаж байхдаа өөрийн мэдэж байсан биеэ үнэлэгчдийн байгууллагаас гадуур бусдад танигдахын тулд мэргэшсэн байх хэрэгтэй байсан. Сайн дураар ажилласнаар шаардлагатай ур чадваруудыг олж авсан. Би гэр оронгуй хүмүүсийн төлөө агентлаг байгуулсан бөгөөд одоо энэхүү ажлаар дамжуулан биеэ үнэлэгчдэд зориулсан төслийн ажилтан гэдэг энэ үүрэг надад олгогдсон.

Би санаа алдлаа. Тиймээ, энэ л мөчийг олон жилийн турш би хүлээсэнсэн.

Тэгээд өөрийн том цүнхээ мөрөн дээрээ шидээд биеэ үнэлэгчдийн цуглардаг газар болох Плимотын улаан дэнлүүний гудамж руу явлаа.

Би машинаа биеэ үнэлэгчдийн цуглардаг гудамжны төгсгөлд найдвартай газар тавилаа. Хүмүүсийн мэдэж байгаагаар үүнийг Нэгдлийн гудамж гэдэг. Дараа нь би биеэ үнэлэгчдийн цуглардаг гудамжны захаар алхав.

Тэр даруйдаа, үйлчлүүлэгчээ хүлээж байгаа нь илт мэдэгдэх эмэгтэйн дурсийг би олж харлаа. Тэр эмэгтэй үйлчлүүлэгчээ түргэн барьж авахыг хүлээж байгаа шавьж мэт харагдаж байлаа. Тэр эмэгтэй үйлчлүүлэгчтэй адилхан үйлдэл хийдэггүй, танихгүй хэнийг ч, юуг ч сэжиглэдэг, ялангуяа өөр эмэгтэй хүнийг сэжиглэдэг.

Би өөрийнхөө харсан эхний эмэгтэй дээр очсон. Ойртох тусам түүнийг таньж байсан. Түүнийг таньсны дараа, миний хамтрагч бол миний мэддэг хүн байна гэж би тайвшираа.

Намайг өөрийн амьдралын шинэ үүргээ тайлбарлаж байхад тэр малгайгаа дээшлүүлэн над руу гайхан харлаа. Миний өөртөө итгэх итгэл хийж байгаа үйл ажиллагаа болж байгаад би маш их баяртай байсан. Би цүнхээ нээж, бэлгийг гаргах зуураа манай шинэ байгууллагын талаар сайн бас гайхалтай гэдэг талаар ярьсаар л байсан. Үүнийг батлахын тулд би дүүрэн бэлгэвчтэй

савыг өргөж, өөрийн хүссэнээрээ ав гэж хэлсэн. Би түүнд: Хэрвээ чи өөрийн асуудлын талаар ярихыг хүсвэл надтай яриарай гэж хэлэв.

Бэлгэнээс авахаасаа өмнө түүний гар нь авах үгүйгээ эргэлзэж байсан. Тэр эргэн тойрноо харж байснаа газар луу ширтэв. Тэр бэлгэнээс авахаасаа ичингүйрч байгааг би мэдэрсэн.

Ямар асуудал байна?

Бид хоёрын хамт ажиллаж байхдаа хуваалцаж байсан түүний сайхан гар хаана байна вэ?

Би түүний хувьд танихгүй хүн мэт санагдсан.

Олон жилийн турш бид их олон дурсамжийг хуваалцаж байсан! Бусад ямар ч эмэгтэйтэй хуваалцдаггүй дурсамжтай байсан.

Миний сэтгэл хөндийрч, хоосорсон.

Би мэргэжлийн байж ажлаа хийх ёстойгоо ойлгон өөрийгөө уучилж, цааш явсан.

Би биеэ үнэлэгчдийн цуглардаг газар очиж, өөрийн очдог байсан газрыг тойрон алхсан. Гэхдээ энэ удаа надтай тааралдсан эмэгтэй миний хийж байсан үйлдэлдтэй адил үйлдэл хийсэн.

Асуудал юунд байна? Би буруу ямар зүйл хийж байсан бэ? Мэдээж охидуудад дэмжлэг мөн хүмүүст танигдахыг хүсч байгаа!

2.

Би Миллбэй хөлөг онгоцны засварын газрын ханыг даган алхав. Харанхуй саарал шөнийн агаартай зохицсон урт саарал өнгөтөй хана. Хог хаягдлууд жихүү даасан салхинд туугдан зам дагуу хийсч байсан. Зам даган хоосон лаазнууд дуутайгаар хийсч байлаа. Гудамж хоосон бөгөөд зөвхөн нааш цааш явах машин, нохойноос өөр юу ч үгүй байлаа. Хаагдаж байгаа шөнийн цэнгээний газраас согтуу хүмүүс гарч ирэхээс өмнө гудамж нам гүм. Энэхүү гудамж нь хоёр өөр ертөнц дунд алхаж байгаа нүүдэлчний газар мэт шал өөр орчин байсан. Чимээгүй байдалд бараг хүрч болох байсан. Би 2 өөр ертөнцийн дунд зогсож байгаа мэт санагдан шөнийн ертөнцид хийх шөнийн ажлын сэтгэлийн хөдөлгөөн замбараагүй гарч ирэхийг хүлээнэ.

Би гудамжаар алхаж байгаад өмнө нь биеэ үнэлэгч байхдаа ажиллаж байсан гудамж руу эргэн алхлаа. Би зам дээр алхаж байгаа өөрийнхөө хөлийг харсаар олон жилийн өмнөх амьдралаа бодож алхлаа. Би өөрийнхөө гутлыг хараад, миний одоогийн өмсөж байгаа энгийн гутал нь солигдож, өмнөх гялтгар гутал болсон бөгөөд миний хөлөнд шилэн оймс өмсөгдсөн байлаа.

Гэнэт салхи миний үсийг нүүр лүү үлээлээ. Би дээшээ харахад миний өмнө булан байна. Энэ бол намайг биеэ үнэлэгч байхад зогсож байсан булан юм. Би зогсов.....

Цаг хугацаа мөн зогсов.

Дурсамж нь далайн долгион мэт бүх биеэр минь буцан ирэв. Дурсамжууд! Бусад охидуудтай хамтран ажилла! Эсвэл нэг нэгнийхээ төлөө санаа тавих нь бидний арга барил болно.

Аюултай бөгөөд хүнд хэцүү үйлчлүүлэгчдийн тухай мэдээллийн цуу яриа. Шинэ охидод дүрмийг тайлбарлахад туслах. Бидний ихэнх нь армийн хүмүүсээс авсан бэлгэвчээ хэрэглэж байгаа эсэхийг батлалгаатай болгох явдал байлаа, яагаад гэвэл эдгээр хүмүүст олон байдаг.

Бид үргэлж ярилцдаг бөгөөд доромжлол ба дээрэлхэх явдалтай нүүр тулахад бие биендээ тусалдаг билээ. Машинтай явж байгаад биднийг хардаг бэлгийн гаж донтой хүмүүстэй бид байнга тааралддаг. Түүнчлэн зарим хүмүүс хүүхдүүдээ дагуулж ирээд тэдэнд: Хэрэв чи буруу замаар орвол тэд нартай адилхан болно гэж биднийг заадаг.

Хүйтэн салхинд би хийсэн зогсож байлаа. Салхи хүчтэй над рүү үлээж, бороо миний мөрөн дээр асгарч, хормын зуур намайг норгосон юм. Миний олон жилийн өмнөх туршлага намайг хамгаалж байгаа учир би хөдлөөгүй.

Миний булан, миний дурьдатгал!

Эртний танил дуу.

Миний мэддэг байсан эмэгтэйчүүдийн сүнс!

Сэтгэцийн өвчтэй болон галзуу хүмүүсийн гаргасан эмэгтэйчүүд.

Эмэгтэйчүүдийн нэрс! Хэт богино, хүчирхийллээр төгссөн ганцаардмал тэдний амьдрал. Тэр харанхуй ба мартагдсан буланд хэвтэх тэдний амьгүй цогцос. Хэн ч санадаггүй, хэн ч гашууддаггүй бөгөөд зөвхөн амьдралд мэдэгдэхгүй үүргээ бие биентэйгээ хуваалцсан.

Хүйтэн бороо нь халуун нулимстай нийлж миний нүүрийг даган урссан.

Бүгдийн төлөө санаа тавьдаг биеэ үнэлэлэгчид, бүхийл хүмүүсийн ээж мэт, мартагдсан, хүн бүрийн янхан гэж доромжлогдсон, хуурамчаар бүжигчин болсон хүмүүсийн нулимс.

Энэхүү харанхуй, хүйтэн ба ганцаардмал буланд таньдаг хүмүүсийн сүнстэй уулзахад хайрын гэрэл нь миний зүрхийг бүрхсэн.

Мартагдсан хүмүүсийн гэрэлд бүх бие усаар угаагдаж, зогсож байхдаа би юу хийх хэрэгтэй гэдгээ мэдэж авсан!

Би бусдыг дорд үзэж өхөлсэн учир буруу зүйл хийж байгаагаа мэдэрсэн. Энэхүү аялал нь зөвхөн миний хүсэл дээр хөтлөгдсөн. Бусдыг дорд үзэх, шүүмжлэх бодлоо би хаясан билээ.

Ичиж шаналсан надаас гарсан уг “Намайг өршөөгөөрэй” гэсэн л уг байлаа.

Written by: Lynne Tansey

Copyright 2003, all rights reserved

<http://www.thestormproject.org/tanseycorner.html>